

**БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНМАУ-ЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН АВТО
ТЭЭВРИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

БНХАУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч талууд" гэх нэрлэнэ/ нь хоёр улсын эдийн засаг худалдааны харилцааг өргөжүүлэх нь нэн чухал гэж үзэж эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хоёр улсын авто тээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл:

Энэхүү хэлэлцээрийг үндэслэн хоёр улсын хооронд харилцан тохиролцож нээсэн хилийн боомтын авто замаар ачаа, зорчигчдыг /жуулчид хамаарагдана/ байнгын болон байнгын бус хугацаагаар тээвэрлэнэ.

Уг тээврийг БНХАУ, БНМАУ-ын бүртгэлтэй автомашинаар гүйцэтгэнэ.

Хоёрдугаар зүйл:

1.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд нь зорчигчдын байнгын тээвэрлэлтийг харилцан хэлэлцэж тохиролцоно.

2.Хэлэлцэн тохирогч талуудын харилцан тохиролцох зүйлд хоёр орны харилцан нэвтрүүлэхээр зөвшөөрөгдсөн зорчигчдын байнгын тээврийн автомашины явах замын чиглэл, зогсох буудал, аялалын цагийн хуваарь, тээврийн хөлс, тээврийн зай, эргэлтийн хугацаа, тээвэр хийх тоо, зардлын хэмжээ болон тээвэрлэгч /тээврийн байгууллагын нэр/ зэрэг хамаарагдана.

3.Хэлэлцэн тохирогч талууд нь зорчигчдын байнгын тээвэрлэлтийн тухай тохиролцохын тулд 2 дугаар заалтад дурдсан зүйлүүдэд оруулах саналын талаарх төслийг урьдчилан нөгөө талдаа өгнө.

Гуравдугаар зүйл :

1.Хоёр улсын хоорондын зорчигчдын байнгын бус тээвэрлэлт нь энэхүү хэлэлцээрийн 4'дүгээр зүйлд зааснаас бусад бүх тохиолдолд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагын

зөвшөөрлийг заавал авах ёстой.

2.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллага эсвэл эрх бүхий байгууллагаас эрх олгосон байгууллага нь зөвхөн өөрийн нутаг дэвсгэрт хамаарах замын хэсэгт автомашиныг нэвтрүүлэн өнгөрүүлэх зөвшөөрлийг олгоно.

3.Зорчигчдын байнгын бус тээвэрт олгосон зөвшөөрлийн бичигт тусгай заалт байхгүй бол уг зөвшөөрлийн бичгээр зөвхөн нэг удаа орох, гарах эрхтэй байна.

4.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд нь харилцан тохиролцсон тэнцүү тоогоор зорчигчдын байнгын бус тээврийн автомашины зөвшөөрлийн бичгийг жилд нэг удаа солилцоно.

Эдгээр зөвшөөрлийн бичиг нь хоёр талын эрх бүхий байгууллага эсвэл түүний эрх олгосон байгууллагын тамга, харжцла - гатны гарын үсэгтэй байвал зохино.

5.Хоёр талын эрх бүхий байгууллагууд нь автомашины зөвшөөрлийн бичгийг солилцох журмыг хэлэлцэн тогтооно.

Дөрөвдүгээр зүйл:

Зорчигчдын байнгын бус тээвэр гүйцэтгэх байгаа автомашинд ямар нэг шалтгаанаар эвдрэл, гэмтэл гарсаны улмаас еер автомашинаар солих болон эвдрэл гэмтэл гарсан автомашиныг хоосон буцаах тохиолдолд 3 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн бичгийг үйлдэх шаардлагагүй.

Тавдугаар зүйл :

1.Хэлэлцэн тохирогч аль нэг талын автомашин нь хоёр улсын хооронд 6 дугаар зүйлд зааснаас еер ачаа тээвэрлэх то - хиолдолд тус тусынхаа эрх бүхий байгууллагаас зөвхөн нэг удаа орох, гарах эрх бүхий зөвшөөрлийн бичигтэй байх ёстой.

2.Хэлэлцэн тохирогч нэг тал нь нөгөө талын автомашинд буцах чиглэлийн ачааг зөвхөн өөрийн хууль ёсны тээврийн төлөөлөгчөөр дамжуулан ачуулах ажлыг зохион байгуулна.

Гэхдээ тухайн улсын дотор өөрсдийн дугаар ачаа олох гйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд хамтран боловсруулсан ачаа тээврийн нэг маягийн зөвшөөрлийн

бичгийг жилд нэг удаа солилцоно.

Энэхүү зөвшөөрлийн бичигт хоёр талын эрх бүхий байгууллагаас томилсон авто тээврийн байгуулагчн тамга, хариуцла - гатны гарын үсэгтэй байвал зохино.

4. Хоёр талын эрх бүхий байгууллагууд нь автомашины зөвшөөрлийн бичгийг солилцох журмыг хэлэлцэн тогтооно.

Зургаадугаар зүйл:

Дор дурьдсан ачааг тээвэрлэсэн автомашинд энэхүү хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн бичгийг үйлдэх шаардлагагүй. Үүнд:

- /1/ Нас барагчийн чандруу, шарил,
- /2/ Нүүж байгаа айлын эд хогшил,
- /3/ Үзэсгэлэн яармаг зохион байгуулахад хэрэглэх үзмэр, тоног төхөөрөмж, материал,
- /4/ Биен тамирын арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах тээврийн хэрэгсэл, амьтан болон төрөл бүрийн багаж хэрэгсэл, эд кмс.
- /5/ Соёл, урлагийн арга хэмжээнд хэрэглэгдэх тайзны засал чимэглэл, хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж кино зураг авах, радио телевизийн программ бэлтгэхэд шаардагдах кмс.
- /6/ Шуудан
- /7/ Эвдэрсэн авто тээврийн хэрэгсэл эдгээр болно.

Техникийн түргэн тусламж үзүүлэх автомашин нөгөө талын улсын хилд ороход зөвшөөрлийн бичиг үйлдэхгүй.

Энэхүү зүйлд заасан ачааг тээвэрлэх автомашин нь заавал өөрийн улсын тээврийн автомашины замын хуудастай байна.

Долоодугаар зүйл:

I. Ачаагүй автомашин, эсвэл хүнд даацн автомашины овор хэмжээ, жин нь хэлэлцэн тохирогч нөгөө талын улсын дотоодод мөрддөг тогтоосон хэмжээнээс хэтэрсэн буюу ажул осолтой ба- раа тээвэрлэсэн бол тээвэрлэгч байгууллага нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авч тээврийн ажлыг гүйцэтгэнэ.

2.Энэхүү зүйлийн I дүгээр заалтад дурдсан тусгай зөвшөөрлийн бичигт замын чиглэлийг тогтоон заасан бол өөр замаар явж болохгүй.

Наймдугаар зүйл :

1.Энэхүү хэлэлцээрт заасан олон улсын тээврийг тухайн улсын хуулийн ёсоор зөвшөөрөгдсөн авто тээврийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

2.Олон улсын тээвэр хийх автомашин нь тухайн улсын дугаартай байхаас гадна тусгай таних тэмдэгтэй байна.

Есдүгээр зүйл :

1. Хэлэлцэн тохирогч нэг талын автомашин нөгөө талын дотоодын тээврийг гүйцэтгэхгүй.

2.Хэлэлцэн тохирогч нэг талын авто тээврийн байгууллага нь нөгөө талын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан нөхцөлд нөгөө талын нутаг дэвсгэрээр дамжин 3 дахь улсад зорчигчид, ачааг тээвэрлэж болно.

3.Хэлэлцэн тохирогч нэг тал дотооддоо хэрэглэгддэг үнэмлэх болон тээврийн холбогдох баримт бичгийн загварыг нөгөө талдаа мэдэгдэж зөвшөөрүүлсэн байна.

4.Зөвшөөрлийн бичиг болон холбогдох баримт бичгийг хятад,монгол хэл дээр хэвлэсэн байх бөгөөд бичилтийг тус тусын хэл дээр үйлдэнэ.

Аравдугаар зүйл :

1.Зорчигчид ба ачаа тээвэрлэх автомашины жолооч нь тухайн автомашиныг жолоодох өөрийн орны эсвэл олон улсын жолоочийн эрхийн үнэмлэхтэй байх бөгөөд автомашин нь тухайн улсын бүртгэлтэй байна.

2.Хэлэлцэн тохирогч талуудын автомашин, жолооч автомашин дээр үйлчилж байгаа ажилтан, тэрчлэн зорчигчид нь нөгөө талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа тэр талын холбогдох хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг сахин мөрдөнэ.

3.Дээрх хоёрдугаар заалтад дурдсан хүмүүс нь Хятад, буюу Монголын хилээс гарахын өмнө холбогдох бичиг баримтыг зохих ёсоор бүрдүүлсэн байна.

Арваннэгдүгээр зүйл :

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд хийгдэх тээврийн зардлын тооцоо болон талбэрийг хэлэлцэн тохирогч талуудын хооронд талбар тооцох журмын дагуу гүйцэтгэнэ.

Гэвч хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд жич хэлэлцээрээр зохицуулагдах зүйл үүнд хамаарахгүй.

Арван хоёрдугаар зүйл:

Хэлэлцэн тохирогч нэг тал нь энэхүү хэлэлцээрийн хүрээнд заасан зорчигчид ба ачааг хоёр улсын хооронд автомашинаар тээвэрлэж буй нөгөө талын авто тээврийн байгууллагыг замын хураамж, автомашины татвар, тээврийн орлого ашгийн аливаа татвараас чөлөөлнө.

Арван гуравдугаар зүйл:

Хэлэлцэн тохирогч талууд хоёр улсын хооронд зорчигчид, ачаа тээврийн үүрэг гүйцэтгэж буй автомашин бүрийг даатгалд хамааруулахаас гадна гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал хийвэл зохино.

Арван дөрөвдүгээр зүйл :

Хилийн байцаан өнгөрүүлэх шалгалт, гааль болон хорио цээрийн шалгалтыг хэлэлцэн тохирогч талуудын хооронд байгуулагдсан хэлэлцээрийн дагуу явуулна. Хэрэв ийм хэлэлцээргүй бол хэлэлцэн тохиролцогч талууд өөрийн улсын дотор мөрдөж байгаа журмын дагуу гүйцэтгэнэ.

Арван тавдугаар зүйл :

Зорчигчид, хүнд өвчтөн, мал түргэн муудах бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа автомашинд хилийн байцаан өнгөрүүлэх болон гаалийн шалгалт, хорио цээрийн шалгалтыг нэн даруй хийж нэвтрүүлэх арга хэмжээг авна.

Арван зургаадугаар зүйл :

I. Хэлэлцэн тохирогч талууд харилцан зорчигчид, ачаа тээвэрлэх үүрэг гүйцэтгэж буй автомашинд олон улсын тээврийн замд хэрэглэх дараах зүйлүүдэд гаалийн татвар, зөвшөөрөл авах шаардлагагүй. Үүнд:

/а/ Бүх төрлийн автомашины хөдөлгүүр болон бусад тоног төхөөрөмжийг ажиллуулахад зориулж түлшний саванд агуулсан шатахуун,

/б/ Тээвэрлэлтийн явцад зайлшгүй шаардагдах тосолгооны материал,

/в/ Олон улсын тээврийн автомашинд хэрэглэгдэх сэлбэг ба багаж хэрэгсэл.

2.Хэрэглээгүй сэлбэг, хэрэгцээ хангахгүй болсон сэлбэг - гийг зарчмын хувьд өөрийн улсруу буцаан тээвэрлэх ёстой. Тэгэхдээ хэрэгцээ хангахгүй болсон сэлбэгийг зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн газарт нь устгал хийж болно.

Арван долоодугаар зүйл:

Энэхүү хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд хэлэлцэн тохирогч аль нэг талын хүсэлт, саналаар хоёр талын эрх бүхий байгууллагууд зорчигчид, ачаа тээвэрлэлтийн явцад гарсан асуудлын талаар уулзалт хийж зөвлөлдөх, туршлага солилцох ба харилцан мэдээлэл хийнэ.

Арван наймдугаар зүйл:

Хэрэв хэлэлцэн тохирогч нэг талын автомашин, эсвэл хүн, хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тухайн орны холбогдох хуулийг зөрчвөл хэлэлцэн тохирогч нөгөө тал өөрийн орны холбогдох хуулийн дагуу зөрчил гаргагчдад шаардагдах арга хэмжээ авах эрхтэй. Гэвч хэлэлцэн тохирогч нэг тал, хэлэлцэн тохирогч нөгөө талаасаа хэргийн талаар авах тодорхой арга хэмжээний тухай мэдээлэл шаардах эрхтэй.

Арван Есдүгээр зүйл:

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэх явцад гарсан аливаа маргаантай асуудлыг зөвлөлдөх, санал солилцох замаар шийдвэрлэнэ.

Ховьдугаар зүйл:

Энэхүү хэлэлцээрт заагдаагүй бусад асуудлыг Хэлэлцэн тохирогч талууд өөрийн улсын дүрэм журмын дагуу зохицуулна.

Хорин нэгдүгээр зүйл :

Энэхүү хэлэлцээрийн утга санаа нь Хэлэлцэн тохирогч талуудаас бусад улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрт заасан эрх, үүрэгт үл хамаарна.

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНМАУ-ЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН АВТО ТЭЭВ-
РИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ
П Р О Т О К О Л

1991 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Бээжин хотоц гарын үсэг зурсан БНХАУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газрын хоорондын авто тээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар хоёр тал дараах зүйлийг тохиролцов. Үүнд:

I. Хэлэлцээрт дурдсан эрх бүхий байгууллага гэдэгт:
БНХАУ-ын талаас :

Хэлэлцээрийн 2; 3; 5; 9; II болон I7 дугаар зүйлд тусгагдсан нь БНХАУ-ын Зам, харилцааны яам, түүний эрх олгосон муж, өөртөө засах орон, улсын шууд харьяалалын хотын зам харилцааны байгууллагууд болно.

Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасан нь БНХАУ-ын Зам, харилцааны яам, БНХАУ-ын/Нийгмийг аюулаас хамгаалах яам, тэдгээрээс эрх олгосон муж, өөртөө засах орон, улсын шууд харьяалалын хотын зам, харилцааны танхим, Нийгмийг аюулаас хамгаалах танхим /товчоо / болно.

БНМАУ-ын талаас :

Хэлэлцээрийн 2; 3; 5; 9; II болон I7 дугаар зүйлд тусгагдсан нь БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх Тээврийн ерөнхий газар, түүний эрх олгосон аймаг, хотын Тээврийг удирдах газрууд болно.

Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасан нь БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх Тээврийн ерөнхий газар, БНМАУ-ын Цагдаагийн ерөнхий газар, тэдгээрээс эрх олгосон аймаг, хотын Тээврийг удирдах газар, цагдаагийн газрууд болно.

2. Энэхүү хэлэлцээрт дурдсан дараах нэр томъёог цорх утгаар тайлбарлана;

2.1. Автомашин гэдэг нь ачаа тээврийн зориулалтын авто машин, чиргүүлтэй автомашин, зүтгүүр болно.

Зорчигч тээврийн хувьд зорчигчид тээвэрлэх зориулалтын 8-аас дээш хүний суудалтай /жолооч орохгүй/ автобус, түүнчлэн зорчигчдын ачаа тээхийг тээвэрлэх зориулалтын чир-

гүүл /автомашин/ болно.

2.2.Байнгын тээвэр гэдэг нь хэлэлцэн тохирогч талуудын тээврийн автомашинаар гүйцэтгэж байгаа замнал, эргэлт, цагийн хуваарь эхлэх цэг, зогсоол, хүрэх цэг зэргийг хоёр талаас хэлэлцэн тогтоосон тээврийг хэлнэ.

2.3.Байнгын бус тээвэр гэдэг нь дээр дурдсан зүйлд хамаарагдаагүй тээврийг хэлнэ.

3.5 дугаар зүйлд дурдсан зөвшөөрлийн бичиг гэдэг нь тээвэрлэгч ба ачаа илгээгч байгууллага /эзэн/-ын тухайн улсын доторх хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэвэл зохих ачааны гаалийн зөвшөөрлийн бичиг энд хамаарахгүй.

4.Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 2 дугаар заалтад дурдсан ачааны автомашины ба зүтгүүр нь хэрэв БНХАУ, БНМАУ-ын бүртгэлийн улсын дугаар, таних тэмдэгтэй бол энэ нөхцөлд чиргүүл, хагас чиргүүл нь бусад улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байж болно.

5.Хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн I дүгээр заалт нь автомашины үйлдвэрээс тухайн автомашин ба зүтгүүрийн түлшний савны багтаамжаар хязгаарласан шатахууны хэмжээ болно.

Тэрчлэн энд чиргүүл, хагас чиргүүл болон хөргөгчтэй автомашины хөргүүлд хэрэглэгдэх шатахуун, ажлын шингэн орно.

6.Хэлэлцээрийн 14, 15 дугаар зүйлд дурдсан хорио цээрийн шалгалт гэдэг нь хүн, амьтан, ургамлын хорио цээрийн шалгалтыг хэлнэ.

Энэхүү протокол нь хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

Протоколд 1991 оны 6 дугаар сарын 24-ний өдөр хятад, монгол хэлээр хоёр хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

林祖乙

